



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Аргачилсан заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 24 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Тариалан, атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ыг гуравдугаар хавсралтаар, “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг энэ зааврын дагуу хийж гүйцэтгэхийг газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил гүйцэтгэх үйл ажиллагаанд энэхүү зааврыг мөрдүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар /Ц.Ганхүү/-т болон бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газар зохион байгуулалтын алба, Гео-экологийн хүрээлэнгийн хамтран 1998 онд баталсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх заавар”, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын “Хот тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр уурхайн дэвсгэр газарт хянан баталгаа хийх журам батлах тухай” 2003 оны 159 дугаар тушаал, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах заавар батлах тухай” 2009 оны 235 дугаар тушаал, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /хуучин нэрээр/-ын даргын “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх түр журам батлах тухай” 2013 оны А/174 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.




Х.БАДЕЛХАН

08 00125